



Бурхан бол Зөвт Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол Зөвт

Attribute: God Is Righteous

Тодорхойлолт: Шударга, үнэн, хүндлэлд зохистой, гэм зэмгүй, цэгц шулуун Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Дуулал 71:14-19** Харин би үргэлж найдаж, Таныг улам ихээр магтах болно. Ам минь Таны зөв шударга, Таны авралыг өдөржин ярина. Учир нь би тоог нь ч эс мэднэ. Би БУРХАН Эзэний хүчит үйлстэй ирнэ. Би Таны зөвт байдлыг Зөвхөн Таныг магтмуй. Бурхан, Та залуугаас минь эхлэн Намайг сургасан. Эдүгээ хүртэл би Таны гайхамшигт үйлсийг тунхагладаг. Бурхан, хөгширч бууралтах үед минь ч Намайг бүү орхиоч, Таны мутрыг би үе удамд, Таны хүчийг ирээдүйн бүх хүнд Тунхаглах хүртэл бүү орхиоч! Учир нь аугаа зүйлсийг хийсэн Бурхан, Таны зөвт байдал тэнгэрт хүрсэн. Бурхан, хэн Тантай адил вэ?
- **Дуулал 116:5** ЭЗЭН нигүүлсэнгүй ба зөвт Тийм ээ, бидний Бурхан өрөвч.
- **Дуулал 129:4** ЭЗЭН зөвт болой. Тэрээр буруутуудын хүлээсээс тасалмуй.
- **2 Коринт 5:21** Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл болгосны учир Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Ефес 4:22-24

Библийн эшлэлээр залбирах:

(Хүүхдийн нэр) маань хуурамч хүсэлдээ шумбан ялзарсан өөрийн хуучин хүнийг тайлж хандлага дотроо шинэчлэгдэн шинэ болох болтугай; Бурхантай адил зөвт ариун дотор бүтээгдсэн шинэ хүнээ өмсөх болтугай.

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Танд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- _____ маань хуурамч хүсэлдээ шумбан ялзарсан өөрийн хуучин хүнийг тайлж хандлага дотроо шинэчлэгдэн шинэ болох болтугай; Бурхантай адил зөвт ариун дотор бүтээгдсэн шинэ хүнээ өмсөх болтугай. *Ефес 4:22-24*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!